

МОНГОЛ УЛС
ҮНЭТ ЦААСНЫ ХОРООНЫ
ТОГТООЛ

1997 оны 11 дүгээр
Сарын 20 –ны өдөр

Дугаар 120

Улаанбаатар
хот

МХБ-ийн үнэт цаасны арилжааны мэдээнд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай

Үнэт цаасны тухай хуулийн 12 дугаар зүйл, зарим үнэт цаасны компанийн бирж дээрх арилжаанд хийсэн шалгалтын дүнг үндэслэн Монгол улсын Үнэт цаасны хорооноос ТОГТООХ нь:

1. Хорооны 1996 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 114 дүгээр тогтоолын хавсралтаар зөвшөөрсөн Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны арилжааны мэдээний "тухайн өдрийн ханш" гэсэн баганын "хаалт" гэсний дараа "дундаж" гэсэн багана нэмж оруулж түүнд тухайн өдөр арилжаалсан тухайн хувьцааны нийт ханшийн жигнэсэн дунджийг гаргаж мэдээлж байхаар тогтоосугай.

2. Энэ шийдвэрийг 1997 оны 12 дугаар сарын 1 -нээс эхлэн мөрдсүгэй.

ДАРГА

Ж.ЯДАМСҮРЭН